

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР**Санамж: 1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.****2. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.**

1. Дараах бодомжуудын аль нь нийгмийг тодорхойлогч гол шинжийг илэрхийлэх вэ? /1 оноо/
 - A. Нийгэм бол амьдралыг цогцлуульж буй хүмүүсийн үйл ажиллагаа
 - B. Нийгэм, байгаль, соёл бол харилцан нөлөөлдөг үнэт зүйлсийн систем
 - C. Нийгэм бол хүмүүсийн бүхэллэг, нийтлэг, гол тогтвортой нэгдмэл байдал, үйлдлийг илэрхийлсэн хамгийн том нэгдэл холбоо
 - D. Нийгэм бол хүн төрөлхтөний чин хүслэнгийн биежилт
 - E. Нийгэм бол угсаатны, соёлын, эдийн засгийн харилцааны цогц
2. Иргэний нийгмийн түгээмэл ойлголтод тохирох хариулт аль нь вэ? /2 оноо/
 - A. Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэж хэрэгжүүлэх таатай орчин
 - B. Иргэн бүрийн хувийн эрх чөлөө, тэгш эрх, сонирхлыг дээдэлсэн нээлттэй нийгмийнтөгтолцоо
 - C. Олон янзын ашиг сонирхол бүхий социал бүлгүүдээс бүрдсэн нийгмийн бүтэц
 - D. Хүний нийгмийн хөгжлийн жам ёсны төлөв байдал
 - E. Нийгэм дэх төрөөс хараат бус бүх төрлийн харилцаануудын цогц
3. Нийгмийн харилцааг албан ёсоор зохицуулагч хэм хэмжээг нэрлэнэ үү? /1 оноо/
 - A. Зан заншил
 - B. Ёс суртахуун
 - C. Эрхзүй
 - D. Уламжлал
 - E. Ёс заншил
4. Ерөнхийлөгчийн сонгуульд улс төрийн намууд нэр дэвшигчийг тодруулах зорилгоор өөрхоорондоо хэлэлцэж шийдвэрээ гаргажээ. Энэ нь нийгмийн харилцааны аль ангилалд хамаарах жишээ вэ? /2 оноо/
 - A. Бие хүмүүс хоорондын
 - B. Бүлэг, нийтлэг хоорондын
 - C. Иргэн, байгууллага хоорондын
 - D. Институт хоорондын
 - E. Нийгэм хоорондын
5. Нийгмийн улс төрийн хүрээний харилцаанд аль өгөгдөл хамаарагдахгүй вэ? /1 оноо/
 - A. Засаглалын харилцаа
 - B. Нийгмийн бүлгүүд болон нийтлэгүүдийн харилцаа
 - C. Төрийн байгууллагуудын харилцаа
 - D. Улс төрийн намуудын харилцаа
 - E. Олон улсын харилцаа
6. Улс төр, эдийн засаг, социал, соёл-оюуны хүрээн дэх хүний амьдралын асуудлуудыг шийдвэрлэдэг хэлбэржсэн харилцаануудын цогцыг гэнэ. /2 оноо/
 - A. Өмчийн харилцаа
 - B. Соёлын хэм хэмжээний харилцаа
 - C. Нийгмийн харилцаа
 - D. Засаглалын харилцаа
 - E. Нийгмийн бүлэг, нийтлэгүүдийн харилцаа
7. Нийгмийн хэв маягийн ангилалд аль нь илүүц вэ? /1 оноо/
 - A. Аж үйлдвэржсэн нийгэм
 - B. Агнуурын нийгэм
 - C. Газар тариалангийн нийгэм
 - D. Иргэний нийгэм
 - E. Аж үйлдвэржсэний дараах нийгэм
8. Нийгмийн хэв маягуудтай шууд хамаарагдах харилцаануудад буруу холбоос орсон болаль вэ? /3 оноо/
 - A. Агнуурын нийгэм – Технологи – Маш энгийн мод, чулуу зэргийг ашигласан
 - B. Энгийн тариалангийн нийгэм – Суурьшил – Хүн амын ихэнх нь хотод суудаг
 - C. Аж үйлдвэржсэн нийгэм – Эдийн засаг – Илүүдэл бүтээгдэхүүн үйлдвэрлэгддэг
 - D. Газар тариалангийн нийгэм – Тэгш биш байдал – Хүн амын олонх нь ядуу тариачид
 - E. Аж үйлдвэржсэний дараах нийгэм – Нийгмийн байгууллагууд – Институтууд
9. Нийгмийн хөдөлгөөн, үйл явцыг судлах түгээмэл хэрэглэгддэг онолын аргуудадхамааралгүй нь аль вэ? /1 оноо/
 - A. Анализ
 - B. Ажиглалт
 - C. Синтез
 - D. Индукц
 - E. Дедуц
10. Материал баялагын нөхөн үйлдвэрлэл, хуваарилалт, хэрэглээ, солилцооны явц дахьхүмүүс хоорондын харилцааны асуудал нь.....амьдралын хүрээнд хэрэгждэг. /1 оноо/
 - A. Улс төрийн
 - B. Социал
 - C. Эдийн засгийн
 - D. Соёл-оюуны
 - E. Эрх зүйн
11. Ардчилсан нийгмийн хамгийн эрхэм үнэт зүйл нь аль вэ? /1 оноо/

A. Хууль B. Төр C. Ёс суртахуун D. Иргэн E. Соёл

12. Нийгмийн амьдралын хүрээнүүдийн шүтэлцээний гол цөм нь юу вэ? /2 оноо/

- A. Бие даасан байдал B. Шийдвэрлэх асуудлын ялгаатай байдал
C. Харилцан үйлчлэлийн үйлдэл, зан үйл D. Чиг үүргийн ялгаатай байдал
E. Холбоо хамаарал

13. Улс төрийн тогтолцоог бүтцийн талаас нь авч үзсэн зөв хариултыг сонгоно уу?/2 оноо/

- A. Нийгэмд үнэт зүйлсийг хуваарилан байршуулах үйл ажиллагаа
B. Улс төрийн харилцааны аливаа төрлийг зохицуулагч бүх байгууллага, тэдгээрийнхооронд үүсдэг харилцан үйлчлэл, тэнд хэрэгждэг хэм хэмжээ, үнэт зүйлсийннийлбэрцогц
C. Нэг нь нөгөөтэйгөө улс төрийн шалтгаан, үр дагавраар нөхцөлдсөн зохих дэс дараатай, системлэг үйл явдлуудын нийлбэр цогц
D. Хүмүүсийн харилцааг зохицуулагч систем
E. Улс төрийн болон бусад харилцаануудын цогц

14. “Улс төр гэдэг нь хэн, юуг, хэзээ, хэрхэн олж авах тухай асуудал” гэж хэн үзсэн бэ?/1 оноо/

- A. Р.Даль B. К.Маркс C. Аристотель D. Г. Лассуэл E. М.Вебер

15. Улс төрийн засаглалын харилцааны онцлог аль нь вэ? /2 оноо/

- A. Тодорхой арга хэрэгслэлийн тусламжтайгаар объектийг хянах
B. Нийгмийн улс төрийн амьдралын хүрээнд үйлчилж буй засаглалын нэгэн хэлбэр
C. Эрх мэдлийг хэрэгжүүлэх тэгш биш харилцаа
D. Төрийн засаглалыг авах, хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдсон улс төрийн субъектуудын хоорондын харилцаа
E. Нийгмийн бүлгүүдийн харилцаанд эсэргүүцлийг даван туулж өөрийн зориг хүслийгнийгмийн бусад хэсэгт нийтлэг хэм хэмжээгээр тулган хүлээлгэх буюу хүлээн зөвшөөрүүлэх чадвар

16. Засаглалын үндсэн хэмжигдэхүүнд илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? /2 оноо/

- A. Засаглалын хэмжээ B. Засаглалын эзэлхүүн C. Засаглалын легитим шинж
D. Засаглалын орон зай E. Засаглалын цаг хугацаа

17. Засаглалын легитим шинжийн үндсэн хэв маягуудыг холбогдох утгатай нь зөвтохируулна уу? /3 оноо/

а	Уламжлалт	1	Удирдагчийн онцгой авьяас чадварт нь итгэх итгэлд үндэслэдэг
в	Харизмат	2	Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ардчилсан хэм хэмжээ, журмын дагуу төрийн шийдвэрт хүмүүс захирагдаж дагаж биелүүлдэг
с	Хууль ёсны	3	Захирах, захирагдах зуршил, ёс заншлийг ариун шударга зүйл хэмээн үздэг

- A. а1, в2, с3 B. а3, в1, с2 C. а2, в1, с3 D. а3, в2, с1 E. а, 1 в3, с2

18. Иргэдийн төлөөлөгчдийн хурал ньюм. /1 оноо/

- A. Засаг захиргааны байгууллага B. Төрийн удирдлагын байгууллага
C. Нутаг дэвсгэрийн байгууллага D. Намын байгууллага
E. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага

19. Социал төрийн бодлого юунд суурилдаг вэ? /2 оноо/

- A. Нийгмийн тодорхой бүлгийн эрх ашгийг хамгаалах бодлогод
B. Төрийн зохицуулалттай зах зээлийн эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх үйлажиллагааны практик үр дүнд
C. Бизнесийн үйл ажиллагааны орчинд
D. Ард түмний сэтгэл хөдлөл, хүлээлтэд
E. Цөөнхийн удирдлагад

20. 1990 оны ардчилсан хувьсгал гарахад ямар хүчин зүйлс нөлөөлсөн бэ? /2 оноо/

- A. ЗХУ-ын /хуучнаар/ задрал, социалист системийн мухардал
 B. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үр ашиггүй байдал
 C. Нэг үзэл суртлын хуваарьгүй туйлшрал
 D. Нэг намын тогтолцооны монополь байдал
 E. Дээрх бүгд зөв
21. Төрийн засаглалыг хэрэгжүүлэх, улс төрийн зорилгод хүрэх арга хэрэгслийг юу гэжнэрлэдэг вэ?
 /1 оноо/
 A. Улс төрийн тогтолцоо B. Улс төрийн үйл ажиллагаа C. Улс төрийн дэглэм
 D. Улс төрийн ноёрхол E. Улс төрийн манлайлал
22. Аристотель засаглалын буруу муу хэлбэрийг аль нь гэж үзсэн бэ? /1 оноо/
 A. Монархи B. Аристократ. C. Полити D. Демократи E. Автократи
23. Ардчиллын сонгодог үзэл санааны гол зарчмуудад аль нь хамаарагдахгүй вэ?/2 оноо/
 A. Төрийн засаглалыг хэрэгжүүлэхэд ард түмэн нийтээрээ оролцох эрхтэй байх
 B. Олон түмэн өөрсдийн төр засгаа сонгож бий болгох эрхтэй байх
 C. Төр нь хүний өмч хөрөнгө, нэр төр, эрх чөлөөг хамгаалах
 D. Төрийн бодлогыг удирдах авьяас бүхий цөөнх тодорхойлох
 E. Иргэд тэгш эрхийн үндсэн дээр улс төрийн хэрэгт оролцох
24. Төрийн засаглалын хэлбэрүүдийг тоочихдоо илүүц зүйл дурдсан бол аль нь вэ?/1 оноо/
 A. Бүгд найрамдах засаг B. Хаант засаг C. Хэмжээт эрхт хаант засаг
 D. Иргэний засаг E. Парламентийн засаг
25. Ардчиллын үндсэн шинж, зарчимд аль нь хамааралгүй вэ? /1 оноо/
 A. Хүний эрх, эрх чөлөө B. Тэгш эрх шударга ёс C. Чөлөөт, шударга сонгууль
 D. Парламентад суудалтай байх E. Хууль дээдлэх
26. Тодорхой бүлэг хүмүүсээс өөрсдийн эрх ашигт нийцсэн шийдвэрийг эрх мэдэл бүхий хүмүүсээр гаргуулахыг оролдсон нөлөөллийн үйл ажиллагааггэнэ. /1 оноо/
 A. Зөвшилцөх B. Лобби C. Эсэргүүцэх D. Хээл хахууль өгөх E. Наймаалцах
27. “Ардчилал бол ард түмнээс сонгогдсон, ард түмний төлөө, ард түмний өөрсдийнх нь засаглал” гэж хэн тодорхойлсон бэ?/1 оноо/
 A. У.Черчилл B. А. Линкольн C. Т. Жефферсон D. Р. Даль E. С.Хантингтон
28. Ажилгүйдлийг бууруулах арга замуудыг холбогдох өгөгдлүүдтэй нь зөв харгалзуулнауу?/3 оноо/

а	Эдийн засгийн	1	Цалин, хөдөлмөрийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, бага дунд үйлдвэрүүдэд дэмжлэг үзүүлэх
в	Захиргааны	2	Хамтарсан хөрөнгө оруулалт хийх, ажиллах хүчийг экспортлох, гадаад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах
с	Гадаад хүчин зүйлийг ашиглах	3	Хөдөлмөрийн биржийн албыг бэхжүүлэх, хүн амын шилжих хөдөлгөөнд хяналт хязгаарлалт тавих
- A. а1, в2, с3 B. а3, в2, с1 C. а1, в3, с2 D. а3, в1, с2 E. а2, в3, с1
29. Худалдан авагч зах зээлээс өөрийн хэрэгцээт бүтээгдэхүүн, үйлчилгээг авсныхаа төлөө худалдагчид төлж байгаа мөнгөн төлөөсийг.....гэнэ. /1 оноо/
 A. Эрэлт B. Нийлүүлэлт C. Өрсөлдөөн D. Зах зээлийн үнэ E. Монополь
30. Инфляцийн сөрөг үр дагавруудад хамаарагдахгүй зүйл аль нь вэ?/2 оноо/
 A. Бизнесийн орчин муудах B. Хүмүүсийн төлбөрийн чадвар доройтох
 C. Ядуурал, ажилгүйдэл өсөх D. Эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр тогтох
 E. Эдийн засгийн бодит өсөлт зогсох
31. Төсвийн зарлагын бүрдэлд хамааралгүй зүйлийг тэмдэглэнэ үү/1 оноо/

- A. Нийгэм соёлын арга хэмжээг санхүүжүүлэх B. Нийгмийн халамжийн зардал
C. Бүх төрлийн татварын орлого D. Батлан хамгаалах зардал
E. Төр засгийн удирдлагын аппаратыг санхүүжүүлэх
32. Өрсөлдөөний эдийн засагт үзүүлэх гол үүргүүдийг тоочихдоо илүүц зүйл дурдсан бол аль нь вэ? /2 оноо/
A. Үйлдвэрлэл, үйлчилгээний чанар үр ашгийг дээшлүүлэх
B. Үнийг тогтворжуулах
C. Зардлыг бууруулах
D. Шинэ техник, технологи нэвтрүүлэх
E. Үйлдвэрлэл үйлчилгээнд хязгаарлалт тогтоох
33. Хязгааргүй хэрэгцээг хязгаарлагдмал нөөц баялгаар оновчтой хангах үүрэгтэй нийгмийн институт аль нь вэ? /1 оноо/
A. Гэр бүл B. Эдийн засаг C. Улс төр D. Боловсрол E. Шашин
34. Инфляци, ажилгүйдлийг аль нь судлах вэ? /1 оноо/
A. Олон улсын санхүү B. Макро эдийн засаг C. Нягтлан бодох бүртгэл
D. Микро эдийн засаг E. Гадаад худалдааны эдийн засаг
35. Чөлөөт зах зээлийн шинжид аль нь тохирохгүй вэ? /1 оноо/
A. Хувийн өмч B. Ашиг олох C. Төвлөрсөн төлөвлөгөө
D. Өрсөлдөөн E. Төрийн оролцоо хязгаарлагдмал байх
36. Өрхийн төсвийн орлогыг бүрдүүлдэг үндсэн өгөгдлийг олж тэмдэглэнэ үү/1 оноо/
A. Хуримтлал, хадгаламж B. Төрийн бус байгууллагуудад төлөх татвар
C. Хүнс тэжээл D. Цалин, хөлс
E. Тээвэр, орон сууц, гэрэл цахилгаан, боловсрол соёлын үйлчилгээний төлбөр
37. Зах зээл гэдэг нь.....юм. /2 оноо/
A. Худалдах худалдан авах хөрөнгүүдийн нийлбэр цогц
B. Эрэлт нийлүүлэлтийн харилцан үйлчлэл
C. Худалдагч ба худалдан авагчийн харилцаа
D. Бүтээгдэхүүн нь таваар болж байгаа үеийн арилжааны эдийн засгийн хэлбэр
E. Дээрх бүгд зөв
38. Монгол улсад шатахуун импортолдог компаниуд нь шатахууны үнийг нэмэхээр тохиролцож буй нь ямар өрсөлдөөнт зах зээлийг илэрхийлэх вэ?/1 оноо/
A. Төгс өрсөлдөөнт B. Олигополь C. Монопольт өрсөлдөөнт
D. Өрсөлдөөнт бус E. Монополь
39. Бараа үйлчилгээ худалдан авахдаа төлсөн нэмэгдсэн өртөгийн татварыг юу гэдэг вэ?/1 оноо/
A. Төлбөр B. Шууд бус татвар C. Хураамж D. Шууд татвар E. Шимтгэл
40. Аливаа орны засгийн газар өөрийн орны зах зээлд оруулах авто машины импортодхязгаар тогтоож байна гэвэл гадаад худалдааны хязгаарлалтын ямар жишээ болох вэ?/2 оноо/
A. Үнэ тарифийн хязгаарлалт B. Демпингийн худалдаа C. Квот тогтоох
D. Лицензийн систем E. Гаалийн татвар
41. Хүүхдийн мөнгөн тэтгэмж нь халамжийн үйлчилгээний ямар төрөлд хамаарагдах вэ?/1 оноо/
A. Нийгмийн халамжийн тэтгэмж B. Нийгмийн халамжийн тэтгэвэр
C. Улсын төсвөөс олгосон тэтгэмж D. Тэтгэмжийн даатгал E. Тэтгэврийн даатгал
42. Нийгмийн давхраажлын дараах хэмжигдэхүүнээс аль нь илүүц вэ?/1 оноо/
A. Эд баялаг B. Эрх мэдэл C. Нас хүйс D. Боловсрол E. Нэр хүнд
43. Бурханы шашны тэргүүн 14-р Далай лам Монголд айлчлан ирж сүсэгтэн олондообуяны ном айлдав. Энэ номын хуралд Монголын хөдөө орон нутгаас олон зуун сүсэгтэн, лам хуварга ирж

- оролцсоны нилээдгүй нь УБ хотод шилжин суурьшижээ.Энэ нь шилжих хөдөлгөөний ямар хэв маягт хамаарагдах вэ?/2 оноо/
 А. Босоо В. Хэвтээ С. Хувь хүний D. Бүлгийн E. Маргинал
44. Нийгмийн даатгалын төрөлд аль нь үл хамаарагдах вэ? /1 оноо/
 А. Тэтгэвэр-тэтгэмжийн В. Ажилгүйдлийн С. Эрүүл мэндийн
 D. Нийгмийн халамжийн E. Мэргэжлээс шалтгаалах өвчний
45. Цэцгээдхүүхэд төрүүлснийх ньдараа тодорхой хэмжээний мөнгө олгосон. Цэцгээгийн авч буй мөнгө нийгмийн хамгааллын ямар хэлбэрт хамаарах вэ?/2 оноо/
 А. Нийгмийн халамжийн тэтгэвэр В. Нийгмийн халамжийн тэтгэмж
 С. Эрүүл мэндийн даатгал D. Ажилгүйдлийн даатгал
 E.Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт
46. Нийгмийн давхраажлын үндсэн хэв маягт аль нь тохирохгүй вэ?/1 оноо/
 А. Боолын В. Иргэний С. Кастын D. Ангийн E. Язгуур
47. Бүтээсэн хүмүүс нь тодорхойгүй авьяаслаг ард олон бүтээсэн соёлыг юу гэж нэрлэдэгвэ? /1 оноо/
 А. Зонхилох соёл В. Элитийн соёл С. Ардын соёл D. Дагуул соёл E. Сөрөг соёл
48. Оюуны соёлд аль нь орохгүй вэ?/1 оноо/
 А. Ёс суртахуун В. Үзэл бодолС. Шинжлэх ухаан D. Мэдлэг E. Барилга байгууламж
49. Соёлын ёс суртахууны хэм хэмжээний үндсэн ойлголтыг нэрлэнэ үү/1 оноо/
 А. Нүгэл, буян В. Сайхан, муухай С. Сайн, муу D. Үнэн, худал E. Дүрэм, журам
50. Соёлын босоо чиглэлийн ангилалд үл тохирох нь аль вэ?/1 оноо/
 А. Элитийн В. Ардын С. Нийтийн D. Оюуны E. Бүгд зөв
51. ШУТИС-ийн залуу багш нано технологийн аргаар усанд нордоггүй даавуубүтээжээ. Энэхүү цоо шинэ үзэл санаа болон шинэ бүтээл хийх үйл явц нь соёлынжишээ юм. Цэгийн оронд тохирох өгөгдлийг нөхнө үү /2 оноо/
 А. Зээлдлэгийн В. Нэвчилтийн С. ШинэчлэлийнD. Статикийн E. Нэгдлийн
52. Соёлын нийлмэл элементүүдэд аль нь тохирохгүй вэ?/1 оноо/
 А. Зан үйл В. Албан хэм хэмжээ С. Ёс заншил D. Уламжлал E. Зан байдлын дүр
53. Улс орнуудын гадаад харилцааны зайлшгүй шаардлагад аль нь онц хамааралгүй вэ?/2 оноо/
 А. Бусад улстай харилцсанаар өөрийн орны байр суурь, нэр хүндийг дэлхийд таниулах
 В. Гадаадын улс орнуудтай харилцаж байж техник технологийн дэвшилтэй холбогдох
 С. Үндэсний соёл, уламжлалаа хөгжүүлэх
 D. Улс орнуудын түүх соёлыг судлах боломж нээгдэх
 E. Даяарчлалын нөхцөлд энэхүү олон улсын харилцаа зайлшгүй болох
54. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалд гадаад бодлогыг ямар төрлүүдэд ангилсан бэ? /1 оноо/
 А. Улс төр, эдийн засаг, боловсрол соёл, хүмүүнлэгийн
 В. Улстөр, эдийн засаг, шинжлэх ухаан- технологи, соёл-хүмүүнлэгийн
 С. Хоёр талын ба олон талт хамтын ажиллагаа
 D. Бүс нутгийн ба тив дамнасан
 E. Бүс нутгийн, олон улсын, тив дамнасан
55. Боловсрол, шинжлэх ухаан, соёлын хамтын ажиллагааг хөгжүүлэх, энх тайванаюулгүй байдлыг бэхжүүлэхэд нөлөөлөх зорилготой НҮБ-ын төрөлжсөн байгууллагыг нэрлэнэ үү./1 оноо/
 А. ЮНИДО В. ЮНИСЕФ С.НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр /UNDP/
 D. ЮНЕСКО E. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага /ДЭМБ/
56. Олон улсын харилцааны субъектэд альнь хамааралгүй вэ?/1 оноо/

- A. Олон улсын байгууллага В. Ард түмэн С. Иргэний нийгмийн байгууллага
D. Төр Е. Үндэстэн дамнасан байгууллага

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР

Санамж: 1.Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож хариуг бөглөөрэй.

2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1. Дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу?/5 оноо/

a	Уламжлалт нийгэм	1	Эрчим хүч, үйлдвэрлэлийн технологи нь нийгмийн хөгжилд гол үүргийг гүйцэтгэдэг
в	Иргэний нийгэм	2	Шинжлэх ухаан, боловсролын үйлчилгээ хөгжиж автоматчилал, компьютер, мэдээллийн технологийг ашигладаг
с	Аж үйлдвэржсэн нийгэм	3	Эрх чөлөөтэй иргэд өвөрмөц сонирхолоороо нэгдэн нийлсэн, төрийн үйл ажиллагааны гадна эрх тэгшээр сонирхолоо хэрэгжүүлэх гэсэн нийгмийн бүлгүүдийн нэгдэл холбоо
d	Коммунист нийгэм	4	Ураг төрлийн харилцаа давамгайлсан, хөдөлмөрийн хуваарийн түвшин дорой, хамтын өмчид суурилсан удирдлагын болхи системтэй, ёс заншил, зан үйлийг тулгуур болгосон том биш нийгэм
e	Аж үйлдвэржсэний дараах нийгэм	5	Хувийн өмчгүй, нийтийн өмчид суурилсан дарлал мөлжлөггүй нийтээрээ эрх тэгш амьдрах нөхцлөөр хангагдсан нийгмийн байгууллын төгс дээд хэлбэр гэж томъёолдог

2.2. Засаглалын нөөцийн төрлүүдийг холбогдох утгаар нь зөв харгалзуулна уу?/5 оноо/

a	Эдийн засгийн	1	Улс төрийн бодлого хэрэгжүүлэх явцад засаглагч өөрийг нь дэмжинэ хэмээн найдаж байдаг нийгмийн бүлэг давхраа хамрагдана
в	Нийгмийн	2	Үйлдвэрлэл хэрэглэнд шаардлагатай материаллаг үнэт зүйл, мөнгө санхүү, техник, технологи, газар нутаг, ашигт малтмал зэрэг ордог
с	Соёл-мэдээллийн	3	Хүчний байгууллага болон тусгайлан бэлтгэгдсэн хүмүүс ордог
d	Хүн амын	4	Засаглалд ач холбогдол бүхий мэдлэг, мэдээлэл тэдгээрийг олж авах түгээх арга хэрэгслүүдийн нийлбэр цогц ордог
e	Албадлагын	5	Хүмүүс материаллаг, соёл, мэдээллийн болон бусад нөөцийг бүтээдэг

2.3. Дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу? /5 оноо/

a	Мөнгө	1	Мөнгө нь бүх тавааруудтай солигдох чадвартай онцгой төрлийн хэрэгсэл
в	Гүйлгээний хэрэгсэл	2	Бараа болон үйлчилгээний ашигт чанарыг мөнгөөр хэмждэг
с	Хуримтлалын хэрэгсэл	3	Бараа үйлчилгээг хоорондоо солилцохдоо хэрэглэхээр бүх нийтээрээ хүлээн зөвшөөрсөн онцгой төрлийн таваар
d	Өртөгийн хэмжүүр	4	Мөнгөөр бүх бараа үйлчилгээг худалдан авч болдог учир ямарч төрлийн төлбөрийг хийж болдог
e	Төлбөрийн хэрэгсэл	5	Мөнгө нь бүх төрлийн бараа үйлчилгээтэй солигдох чадвартай учир хадгаламж болгон ашигладаг

2.4. Дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу?/5 оноо/

a	Брахманууд	1	Хамгийн дорд ажил
в	Кшатрий нар	2	Санваартан дээд лам нар
с	Вайша нар	3	Вант улсын захирагчид, цэрэг дайчид
d	Шудра нар	4	Худалдаачид, гар урчууд
e	Үл хамаарагсад	5	Тариачид, зарц, ажилчид

